

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДОРНОГОВЬ АЗЗА” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн
аудит

Аудитын код: САГ-2019/16/СТА-БСД

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	7
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	8
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1.	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	13
4.2.	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	14
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	16

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ДОРНОГОВЬ АЗЗА” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.БАТТОГТОХ ТАНАА

2019.03.15 № 06/487
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажуулсан болно. зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг татварын зорилгоор элэгдэл байгуулаагүйгээс 11.9 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгийг тайлагнаагүй, Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланд тусгаагүй нь Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах" журмын 3 дахь заалтыг мөрдөөгүй ба өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь санхүүгийн тайлангийн бодитой оршин байх ба тохиолдсон байх, үүрэг ба хариуцлага, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

"Дорноговь АЗЗА" ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус компанийн гүйцэтгэх захирал А.Баттогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорноговь АЗЗА ТӨХК -ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан, тодруулга дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 25-наас 2019 оны 3 дугаар сарын 7-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Шинэ их тэрбум аудит” ХХК-ийн захирал Ц.Мишигдорж, аудитор Ц.Цэцэгмаа, аудиторын туслах Д.Болд нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь АЗЗА ТӨХК 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгыг “Шинэ их тэрбум аудит” ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажуулсан болно. зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Дорноговь АЗЗА ТӨХК нь “Зөв төлөвлөлт, чанартай бүтээн байгуулалт, үр дүнтэй хяналт” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь АЗЗА ТӨХК авто зам, замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрөл эзэмшдэг, дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Хатуу хучилттай зам барих;
- Хайрган хучилттай зам барих;
- Хатуу болон хайрган хучилттай зам засварлах;
- Төмөрбетон, ган төмөр, модон гүүр засварлах;
- Зам, замын байгууламжид хамаарах талбай барих, засварлах;
- Үерийн хамгаалалтын далан барих.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Компанийн тухай хууль
- Авто замын тухай хууль
- Татварын багц хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь АЗЗА ТӨХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Венница” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь АЗЗА ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж,

санхүүгийн тайлан, тодруулгын тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг сонгов.

Энэ нь байгууллагын тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзсэнтэй холбоотой юм.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2018 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 1,499.9 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 15.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь үйл ажиллагааны цар хүрээтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр гүйцэтгэлийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудлыг шинээр нэмж илрүүлэн, аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар хөрөнгийн үнэлгээтэй холбоотой бичилт, тооцооллын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Дорноговь АЗЗА ТӨХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Хөрөнгийн үнэлгээний тайлангаарх конторын барилгын бууралт, харуулын байрын өсөлт, бусад хөрөнгийн өсөлтийнг дүнг санхүүгийн бүртгэлд 248.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг;
- 179.9 сая төгрөгийн газар эзэмших эрхийн үнэлгээг газрын сайжруулалт дансанд бүртгэснийг тус тус залруулав.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	31.8	Татвар, санхүүгийн бүртгэлтэй холбоотой
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	31.8	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад дараагийн аудитаар авч үзэх дараах асуудлууд: Үүнд:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн болон татварын зорилгоор зэрэгцүүлэн тооцсон эсэхийг шалгах;
- Татварын тайлангаарх үлдэгдэл дүнг баталгаажуулж, санхүүгийн тайланд залруулга хийсэн эсэхийг шалгах;

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд 1,100.0 сая төгрөгийн орлого, 1,075.0 сая төгрөгийн зардлыг төлөвлөж, гүйцэтгэлээр 1,400.8 сая төгрөгийн орлого олж, 1,395.1 сая төгрөгийн зардлыг зарцуулж, 5.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж, зорилтот түвшинг 25 хувиар биелүүлсэн.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь АЗЗА ТӨХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2018 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, тухайн жилийн зорилтот түвшин, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьтай байгаа нь санхүү ба татварын элэгдлийн зөрүүг Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланд тусгаагүй зөрчил давтагдсан.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь АЗЗА ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг татварын зорилгоор элэгдэл байгуулаагүйгээс 11.9 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгийг тайлагнаагүй, Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланд тусгаагүй нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам”-ын 3.1-3.3-т заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Татвар ногдуулах орлогыг бууруулсан байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчилтэй асуудлыг хүлээн зөвшөөрсөн.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Татварын албанд хянагдсан тайлангийн үлдэгдэл нь санхүүгийн тайланд дараах хэмжээний зөрүүтэй илэрхийлэгдсэн.

- Цалин хөлс ба түүнтэй адилтгах орлогоос суутгасан татвар 0.4 сая төгрөгөөр дутуу,
- Хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 3.0 сая төгрөгөөр илүү,
- Нэмэгдсэн өртгийн албан татвар 6.8 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д заасан “үнэн зөв байх” зарчмыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Татварын тайлангаар гарсан авлага, өглөгийн дүнгүүд нь санхүүгийн тайланд зөрүүтэй илэрхийлэгдсэн байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Татварын тооцооны үлдэгдлийг санхүүгийн тайлан, татварын тайланд зөрүүгүй илэрхийлж байх, зөрүү үүссэн шалтгааныг тодорхойлж, татварын албанд хандаж, залруулга хийх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчилтэй асуудлыг хүлээн зөвшөөрсөн.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Хувь хүмүүсээс худалдан авсан 94.9 сая төгрөгийн бараа материалын дүнгээс 9.5 сая төгрөгийн албан татвар суутган авсан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн “18.1 Үйл ажиллагааны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо холбогдох зардлыг хасч тооцно, 27.1. Албан татвар төлөгч албан татвар ногдуулах орлогоо энэ хуулийн дагуу өөрөө үнэн зөв тодорхойлж, албан татварыг төсөвт төлнө.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Хувь хүний орлогын албан татварыг хуулийн дагуу тооцоогүйгээс үндэслэлгүйгээр татвар суутган авсан.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний бараа борлуулсны орлого нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн “хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх, зэргээр олсон үйлдвэрлэл арилжааны орлого” гэсэн заалтад хамаарах бөгөөд татвар төлөгч албан татвараа өөрөө тодорхойлж төлөх үүрэгтэй гэсэн заалтыг дагаж мөрдөх;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчилтэй асуудлыг хүлээн зөвшөөрсөн.

3.4 Балансын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн үлдэгдэл нь санхүүгийн тайланд 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тохиолсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д заасан “үнэн зөв байх” зарчмыг тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн дүнгүүд хоорондоо зөрүүтэй байх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Зөрүү үүссэн шалтгааныг тодорхойлж, залруулга хийх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчилтэй асуудлыг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1.	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	305,927,548.44	91,466,267.36
1.1.2	Дансны авлага	33,044,931.91	305,804,102.53
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		1,332,291.34
1.1.4	Бусад авлага		109,999.08
1.1.5	Бараа материал	217,974,306.27	280,700,114.84
1.1.6	Урьдчилж төлсөн зардал	34,646,312.68	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	591,593,099.30	679,412,775.15
1.2.	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	703,553,816.06	654,616,336.31
1.2.2	Биет бус хөрөнгө	54,166.52	179,930,500.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	703,607,982.58	834,546,836.31
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,295,201,081.88	1,513,959,611.44
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	48,900,000.00	8,999.94
2.1.1.2	Цалингийн өглөг	37,102,132.99	
2.1.1.3	Татварын өр		19,910,480.94
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	86,002,132.99	19,919,480.88
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	295,518,696.00	295,518,696.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	295,518,696.00	295,518,696.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	381,520,828.99	315,438,176.88
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: а.төрийн	1,259,316,594.42	1,259,316,594.42
2.3.2	Нэмж төлөгдсөн капитал	31,497,846.00	31,497,846.00
2.3.3	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	83,989,232.03	194,029,397.66
2.3.4	Эздийн өмчийн бусад хэсэг	28,114,800.00	197,369,215.82
2.3.5	Хуримтлагдсан ашиг	(489,238,219.56)	(483,691,618.96)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	913,680,252.89	1,198,521,434.56
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,295,201,081.88	1,513,959,611.44

4.2. Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	1,427,174,772.69	1,396,569,660.11
2	Борлуулалтын өртөг	1,312,114,744.67	1,302,394,875.76
3	Нийт ашиг (алдагдал)	115,060,028.02	94,174,784.35
5	Хүүний орлого	1,431,057.31	
8	Бусад орлого		4,184,025.12
10	Ерөнхий ба удирдлагын зардал	113,137,624.65	92,641,577.83
17	Бусад ашиг (алдагдал)	3,936,539.32	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	7,290,000.00	5,717,231.64
19	Орлогын татварын зардал	729,000.00	170,631.04
20	Татварын дараах ашиг (алдагдал)	6,561,000.00	5,546,600.60
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	6,561,000.00	5,546,600.60
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,259,316,594.42		31,497,846.00	83,989,232.03		28,114,800.00	(494,607,709.56)	908,310,762.89
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(1,191,510.00)	(1,191,510.00)
3	Залруулсан үлдэгдэл	1,259,316,594.42		31,497,846.00	83,989,232.03		28,114,800.00	(495,799,219.56)	907,119,252.89
4	Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/							6,561,000.00	6,561,000.00
9	2017 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	1,259,316,594.42		31,497,846.00	83,989,232.03		28,114,800.00	(489,238,219.56)	913,680,252.89
11	Залруулсан үлдэгдэл	1,259,316,594.42		31,497,846.00	83,989,232.03		28,114,800.00	(489,238,219.56)	913,680,252.89
12	Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/							5,546,600.60	5,546,600.60
14	Өмчид гарсан өөрчлөлт						169,254,415.82		169,254,415.82
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				110,040,165.63				110,040,165.63
17	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,259,316,594.42		31,497,846.00	194,029,397.66		197,369,215.82	(483,691,618.96)	1,198,521,434.56

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,471,606,672.31	1,285,438,951.12
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,458,198,923.21	1,273,019,435.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,959,105.00	2,186,448.00
	Бусад мөнгөн орлого	10,448,644.10	10,233,068.12
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,386,594,641.19	1,475,054,681.20
	Ажиллагчдад төлсөн	269,236,335.48	336,004,095.41
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	105,957,839.44	77,364,488.98
	Бараа материал худалдан авахад төлсөн	800,605,144.27	737,062,280.85
	Ашиглалтын зардалд төлсөн	6,573,259.00	17,408,952.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	138,042,087.00	166,125,294.00
	Татварын байгууллагад төлсөн	66,179,976.00	141,089,569.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	85,012,031.12	(189,615,730.08)
2	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		(24,845,551)
	Төлсөн ногдол ашиг		(24,845,551)
2.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(24,845,551)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	85,012,031.12	(214,461,281.08)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	220,915,517.32	305,927,548.44
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	305,927,548.44	91,466,267.36

Эдийн засгийн зорилтот түвшингийн төлөвлөгөө ба гүйцэтгэл

Үзүүлэлт	2018		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	1,100,000.00	1,400,753.70	(300,753.70)	127.3%
Улсын чанартай зам засвар арчлалтын ажил	700,000.00	929,497.30	(229,497.30)	132.8%
Орон нутгийн чанартай замын ажил	400,000.00	448,775.10	(48,775.10)	112.2%
Бусад орлого		18,297.30	(18,297.30)	
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал		4,184.00	(4,184.00)	
Нийт орлого	1,100,000.00	1,400,753.70	(300,753.70)	127.3%
Нийт зардал	1,075,000.00	1,395,036.40	(320,036.40)	129.8%
Удирдлагын зардал	149,186.80	92,641.60	56,545.20	62.1%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	925,813.20	1,302,394.90	(376,581.70)	140.7%
Татвар төлөхийн өмнөх ашиг	25,000.00	5,717.30	19,282.70	22.9%
Цэвэр ашиг	22,500.00	5,546.60	16,953.40	24.7%

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн
аудитын хураангуй тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/16/СТА-БСД
Шалгагдсан байгууллагын нэр:	"Дорноговь АЗЗА" ТӨХК				Сая төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5			9	10
1	Балансын данстай холбоотой асуудал	1	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг татварын зорилгоор элэгдэл байгуулаагүйгээс 11,919.0 мянган төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгийг тайлагналгүй, Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланд тусгаагүй, өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй	11.9	Зөвлөмж өгөх	2019.03.14		Нягтлан бодогч	Б.Тунгалагтуяа

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	Балансын данстай холбоотой асуудал	1	Татварын тайлангийн үлдэгдэл нь Цалин хөлс ба түүнтэй адилтгах орлогоос суутгасан татвар 450.6 мянган төгрөгөөр дутуу, Хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 3,000.7 төгрөгөөр илүү, НӨАТ 6,782.8 мянган төгрөгөөр илүү санхүүгийн тайлангийн зүйлсээс зөрүүтэй илэрхийлэгдсэн.	10.2	Зөвлөмж өгөх	2019.03.14		Нягтлан бодогч	Б.Тунгалагтуяа
3	Балансын данстай холбоотой асуудал	1	Хувь хүнээс худалдан авсан 94,979.0 мянган төгрөгийн бараа материалын дүнгээс 10%-иар суутганы татвар суутгасан	9.5	Зөвлөмж өгөх	2019.03.14		Нягтлан бодогч	Б.Тунгалагтуяа
4	Балансын данстай холбоотой асуудал	1	Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн үлдэгдэл нь санхүүгийн тайланд 203.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн	0.2	Зөвлөмж өгөх	2019.03.14		Нягтлан бодогч	Б.Тунгалагтуяа
	Нийт дүн			31.8					

Бэлтгэсэн: Аудиторын туслах:

Д.Болд

Огноо

Анхан шатанд хянасан: Менежер:

Д.Дашдулам

Огноо

Хоёр дахь шатанд хянасан:
Захирал

Ц.Мишигдорж

Огноо